



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/664

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмнө нь газар өмчилсөн 1 иргэний газрын хэмжээг кадастрын зураглалын дагуу өөрчилж хавсралтаар өмчлүүлсүгэй.

2. Өөрчилсөн газрын хэмжээг хууль тогтоомжийн дагуу тэмдэгжүүлэн газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны Б/111 дүгээр захирамжаас тухайн иргэнтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010934

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/664 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ИРГЭДИЙН НЭРС, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Өмчлөгчийн						Өмнөх газрын хэмжээ /м2/	Өмчлөх газрын хэмжээ /м2/	Өмчилж авсан үнэ	Аймгийн Засаг даргын захирамжид өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хэсэг
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Хаяг	Нэгж талбарын дугаар				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Боржигон	Бат-Эрдэнэ	Баяржаргал	ГА96071101	Булган сум 6 дугаар баг Ухаарал 15 дугаар гудамж 1502 тоот	6308008459	1185	1308	4578000	Аймгийн Засаг даргын 2015 оны Б/111 дугаар захирамжаас газрын хэмжээ өөрчлөх